

STUDIA FOLCLORICA
FOLKLORE STUDIES

<https://doi.org/10.5564/sf.v45i1.4815>

Tom. XLV

2024

fasc. 6

Монгол домгийн судалгааны тойм

Молор-Эрдэнийн СЭЦЭНТУНГАЛАГ*
МУБИС-ийн НХУС-ийн Утга зохиолын тэнхим

Аюушжавын АЛИМАА**
Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Аман зохиол судлалын салбар

Received: May 30, 2024

Revised: Jun 26, 2024

Accepted: Jul, 25, 2024

Хураангуй: Домог нь нийгэм, хүмүүнлэг, цаашилаад байгалийн ухаан, шашин судлал зэрэг томоохон салбарт давын өмнө авч үздэг, зайлшгүй судлагдахуун билээ. Монгол домгийн судалгааны тойм өнөө хэр цэгцтэй бичигдээгүй байгаа бөгөөд Монгол домгийг цуглуулах, эмхэтгэн хэвлүүлэх, судлах (сурталчлах), өөр хэлнээ орчуулах замаар харьцуулсан судалгаа хийх зэрэгт судалгааны тойм чухал юм. Иймд тус тоймыг бичигчид Монгол Улс болон буриад, халимаг, Өвөр монголын аман зохиолч, гадаадын монголч эрдэмтдийн сэдэвт хамаарах голлох бүтээлүүдийг онцлон дурдах замаар “Монгол домгийг гадаадын эрдэмтэд судалсан товч тойм”, “Буриад болон Халимаг дахь монгол домгийн судалгааны товч”, “БНХАУ-ын ӨМӨЗО-ы эрдэмтдийн судалгааны товч тойм”, “Монгол Улс дахь домгийн судалгааны товч тойм” хэмээн бүлэглэж цуваа цагийн дагуу (1876-2024) товч дүгнэлттэйгээр бичжээ.

Түлхүүр үг: Монгол аман зохиол, домог (myth), домог зүй, Монгол домог, судалгааны тойм, тойм судалгаа

A overview of research on
Mongolian myths

SETSENTUNGALAG Molor-Erdene
Mongolian State University of Education, School of
Humanities and Social Sciences, Department of Literature

ALIMAA Ayushjav
Department of the Folklore studies, Institute of Language and
Literature, Mongolian Academy of Sciences, Mongolia

Abstract: Myth and mythology is an important and indispensable subject of study in major fields such as humanities, sociology and even natural sciences and religious studies. A systematic review of Mongolian mythology has not yet been written. A review of Mongolian mythology research is important for collecting Mongolian myths, compiling, publishing, studying (promoting) and comparative study of Mongolian myths through translation into other languages. Therefore, the authors of this review have written a scientific review based on the main works on this topic by Mongolian, Buryat, Kalmyk and Inner Mongolian folklorists, as well as foreign Mongolologists. At the same time they are grouped in this review as ‘A Brief Review of the Study of Mongolian Mythology by Foreign Scholars’, ‘A Brief Review of the Study of Mongolian Mythology in Buryatia and Kalmykia’, ‘A Brief Review of the Study by Scholars of the Inner Mongolia Autonomous Region of China’ and ‘A Brief Review of the Study of Mythology in Mongolia’ and written in chronological order with brief conclusions.

Key words: mythology, Mongolian myths, natural, Buryat, Kalmyk

Нэг. Монгол домгийг гадаадын эрдэмтэд судалсан товч тойм

Монгол домгийн судалгаанд Оросын эрдэмтэн, судлаачид томоохон байртай билээ. Оросын нэртэй судлаач, аялагч Г.Н.Потанин, И.П.Беннигсен нарын алдар юун түрүүнд дурдагдах нь зүйн хэрэг. Учир нь эдгээр хүмүүс монгол домгийг дэлхий дахинаа анхлан мэдээлэгчид юм. Тэгэхдээ домог гэдэг төрлөөр цуглуулж ном бүтээлдээ ялган орчуулж, хэвлүүлжээ.

Г.Н.Потанин 1876-1880 онд Монгол орноор аялан явж монгол аман зохиол, түүний дотор домгийг сурвалжлан цуглуулах анхлагч болсон билээ. Тэрээр “Тангад-Төвөдийн хязгаар, Хятад ба Төв Монгол” (Потанин Г.Н, Тангутско-Тибетская окраина Китая и Центральная Монголия., Т-1 1882; Т-2 1889) номын II боть, “Баруун хойд монголын тэмдэглэл” (1876-1877) -ийн II болон IV ботид монгол домгийн дурсгал орос хэлээр орчуулагдан хэвлэгдсэн байдаг.

Оросын гүн А.П.Беннигсен 1912 онд “Төв Азийн домог, үлгэрүүд” номоо Төв Азийн Монгол, Киргиз зэрэг улс орноор аялан явж байхдаа цуглуулсан ардын үлгэр, домгийг эмхэтгэн хэвлүүлсэн юм. Уг бүтээлд “Монгол домгоос” гэсэн хэсгийн дотор ертөнц үүдэн бүтсэн, тэмээ үнсэн дээр хөрвөөх болсон,

* © М.Сэцэнтунгалаг
Email:hsqtlg@gmail.com 88673229

** © А.Алимаа
Email: Alimaaa@mas.ac.mn

тагтаа гүвтнэдэг болсон, нарс, хуш, арц мөнх ногоон болсон тухай зэрэг монголчуудын мэддэг домгууд энэ номд анхлан орсон юм.

Хэл шинжлэлч, орчуулагч, яруу найрагч В.Н.Клюева (1894-1964) Казаны их сургууль төгссөн бөгөөд 1944-1950 онд Монгол Улсад, МУИС-д томилогдон ирж ажиллаж байхдаа монгол аман зохиолыг сонирхон цуглуулж, судалж, орос хэлнээ орчуулж байв. Академич Д.Цэрэнсодном “Монголчуудын ардын уран бүтээл” өгүүлэлдээ домог үлгэрийн тухай томъёолоод, 10 тооны домгийг түүнд хамаатуулан өгүүлжээ. Бид энэхүү өгүүллийг “Народное творчество Монголии” нэрээр 1958 онд “Современная Монголия” сэтгүүлийн Дугаар 4-т хэвлүүлсэн өгүүлэл болов уу гэж таамаглаж байна. Харамсалтай нь мөн эсэх, орчуулгын бүтээл үү, өгүүлэл үү гэдгийг мэдэж, үзэж чадсангүй.

Эрдэмтэн Г.И.Михайлов “Монголчуудын баатарлаг туульс дахь луу ба лус” (Михайлов Г.И., 1963, No.63, 75-79) болон “Монгол ардын баатарлаг туульс дахь домгууд” (Михайлов, 1963, No.83, 109-119), “Халимагийн Жангар ба домог” (Михайлов Г.И., 1976, No. 14, 3-27), “13-19 дугаар зууны монголчуудын түүхэн сурвалж дахь домгууд” (1983) зэрэг өгүүлэл хэвлүүлж туульс ба домгийн сэтгэлгээг харьцуулсан үзсэн байна.

Орос, Зөвлөлийн эрдэмтэн К.Вяткина монголчуудын морь шүтлэгийн тухай (1968), Л.Н.Гумилев “Эртний монголчуудын шүтлэг” (1968), судлаач Т.А.Бертагаев монгол домгийн чиглэлээр “Монгол овогтны шүтээн эх ба гал шүтлэг” (1973), “Монгол овогтны домог дахь од эрхсийн төсөөлөл” (1975), мөн Н.Жуковская “Монгол соёл дахь домгийн ба түүхэн, ахуйн цаг хугацаа” (1984) Э.А.Новгородова “Эртний Монголын домог ба шүтлэг” (1986) зэрэг өгүүллийг дурдаж болох байна.

Оросын эрдэмтэд 1970 оноос бэлтгэж 1980 оноос хэвлүүлсэн “Мифы народов мира” тольд монгол домог зүйн үндсэн ойлголтуудыг бичсэн нь өдгөө үнэ цэнтэй хэвээрээ байна. Тэдгээрийг Сергей Юрьевич Неклюдов голлон бичсэн юм. Тухайлбал, “Дэлхийн ард түмний домог” номын 1994 оны хэвлэлд “Долон эбуген” (Боть 1. с. 391), “Монгол домог зүй” ерөнхий ойлголт (Боть 2. с. 170–174), Ойрад-халимагийн домог зүй (Боть 2. С. 247–248) гэх мэт.

С.Ю.Неклюдов 1992 онд “Полистадиальный образ духа-хозяина, хранителя и создателя огня в монгольской традиции” (Неклюдов, 1992/1993, Т. XLVI (2-3), 311-321) (Монгол уламжлал дахь гал сахигч, гал бүтээгч эзний шаталсан дүр); “Монгольская мифология: Религиозные и повествовательные традиции” (Монгол домогзүй: шашны болон хүүрнэлийн уламжлал) (Неклюдов А., Мифология и литература Востока., 1995, 67-77) тэрчлэн 2004 онд “Мифы и религии мира” (Неклюдов А., Мифы и религии мира, 2004) зэрэг бүтээл бичсэнээс 2019 онд “Фольклорный ландшафт Монголии” цувралаар хэвлэгдсэн “Миф и обряд” (Домог ба зан үйл) бүтээл онцгой юм. Учир нь энэ ном судлаачдын дунд байсан “Монголчууд домог үлгэртэй юу?” гэдэг эргэлзээг бүрэн тайлсан гэж болно. Бүтээлийн зорилго нь монгол үндэсний соёлын бүрэлдэхүүн зан үйл-домог зүйн үндэс болсон хэсгүүдийг задлан шинжлэх,

монголчуудын ертөнцийн тухай ойлголт төсөөлөл, түүхэн явцад домог үлгэр өгүүлэгдэхүүн дамжигдах, хувилбарлах байдал, ардын уламжлалд дасан зохицох, зан үйл, домог зүйн харьцааг тодруулахад чиглэгдсэн нь орчин үеийн аман зохиолын судалгааны олон асуудлыг хөндсөн байна.

Монгол домгийг бусад улсад судалсан тойм баялаг гэж болно. Германы монголч эрдэмтэн В.Хайссиг монгол домог, бөөгийн шүтлэгийн талаар судалж нэлээд тооны бүтээл хэвлүүлжээ. Тухайлбал, В.Хайсигийн “Tibet und die Mongolei als literarische Provinzen” (Heissig, 1967, Heft 132), “Сүлд тэнгэрийн тахилгын нэгэн бичвэр” (Heissig, Ein text zum Kult des Su’lde Tengri. Ed. K Ro’hrborn and N.W. Brands. , 1981, 84-102), “Бөөгийн домог ба овгийн туульс” (Heissig, Shaman myth and clan epic. Schamaism in Euroasia. Ed. M.Hoppal, 1984, pt.2, p.319-324) зэрэг өгүүлэл бичсэний зэрэгцээ монгол бөөгийн шүтлэгийн чиглэлээр ч цөөнгүй бүтээл туурвисан билээ.

Унгарын эрдэмтэн Л.Лөринц монгол домог зүйгээр үндсэндээ дагнасан судалгаа хийдэг эрдэмтэн байв. Тэрээр “Монгол аман зохиол дахь мангасын тухай” (Lo’rincz, 1970, 309-340), “Монгол домог” (Lo’rincz, Die mongolische Mythologie. \Acta Orientalia., 1972, T. 27, fasc. 1, 103-126.) (Олон улсын монголч эрдэмтний II их хуралд тавьсан илтгэл) зэргийг бичиж байгаад 1975 онд “Монгол домог” номоо Будапештэд хэвлүүлсэн билээ (Lo’rincz, Mongol mifologia., 1975, -241). 1977 онд “Монгол домгийн соёлын баатрууд ба нарны домог, нарны баатар” өгүүлээ “Acta Orientalia” сэтгүүлийн 31 дэх ботид хэвлүүлснээс хойш монгол домог зүйн хэд хэдэн өгүүлэл бичсэн байдаг. Мөн доктор Берталан Агнеш зэрэг Унгарын судлаачдын бүтээлүүд (хөтөлбөр) бий. Тухайлбал, Birtalan A. Tanulmányok a mongol népi hiedelemvilágról [Монголчуудын шүтлэг бишрэл. Бидний өвөг дээдсийн мөрөөр] (Budapest, Nemzeti Tankönyvkiadó 1996. 177 p), түүнчлэн А.Берталаны редакторлаж өмнөх үгийг бичсэн “Miért jön a nyárra tél? [Өвөл яагаад зун болж хувирдаг вэ?] Mongol eredetmitoszok, mondák. Ed. Birtalan, Ágnes (Budapest, Terebess Collection 1998. 120 p.) номыг дурдаж болно.

Чехийн эрдэмтэн Vacek 1983 онд Монголын эрдэмтэн, домог зүйч С.Дуламын хамт “A Mongolian Mythological text” (Studia Oriental Pragensia) ном хэвлүүлсэн нь монгол домгийн тэнгэр нэрүүд, галав ертөнцийн судалгаанд чухал судлагдахуун болсон билээ.

Японы эрдэмтдийн монгол домгийн судалгааны түүх багагүй юм. Гол төлөөлөгч Шаратори Күракич 1912 онд “Монголын эртний домог” (бүртгэл) -ийг хэвлүүлж анхдагч болсон бол “Монголын аман үлгэр” өгүүлээ “Зүүн Азийн судлал” сэтгүүлд (1912), “Монголын эртний домог” өгүүлээ “Зүүн Азийн гялбаа” сэтгүүлд (1919), “Түрэг хийгээд эртний монголын домог” (“Түүх судлал” сэтгүүл. 1938), “Чингис хааны домог” (Шин Лианы нийгэмлэгийн мэдээ. 1938) зэргийг хэвлүүлжээ. 1970 онд түүний зохиолын “Бүрэн түүвэр” Ян Бү Вэ хэвлэлийн газарт хэвлэгдсэн бөгөөд энд түүний монгол домог зүйн бүтээл багтсан байна. Түүнчлэн Найто Кунаны “Зүүн хойд Азийн эл улсуудын гэрлээр мэндэлсэн домог” (“Үндэстэн ба түүх” номд. 1919), Комай Ёшинкийн

“Чингисийн домог” (“Түүхийн сэтгүүл”. 1939), “Монголчуудын ертөнцийг бүтээсэн үлгэр” (“Шин линий мэдээ” сэтгүүл. 1940), “Чингис хааны домог” (мөн нийгэмлэгийн сэтгүүл. 1940 оны 95, 1114-1147), Тамура Зицу “Монгол улс байгуулагдсан домог хийгээд нүүдэл суурьшлын асуудал” (“Дорно дахины түүх” 1964), Мураками Масай “Монгол аймгийн өвөг дээдсийн уламжлал хийгээд аймгийн нийгмийн бүтцийн тухай” (“Түүхийн судлал” сэтгүүл. 1964), Намуми Нарү “Монголын нууц товчооны аман уламжлалын урлагийн судлал” (1975) зэрэг бүтээлийг дурдаж болох юм.

Судлаач Наката Чионье Оросын аялагч Г.Н.Потанины “Монгол домог үлгэр” бүтээлийг орчуулан 1941 онд Бээжинд хэвлүүлсэн бол Дорж Банзаровын “Харын шүтлэг ба бөө мөргөл” бүтээлийн орчуулга 1942 онд “Умард Азийн эрдэм шинжилгээний сэтгүүлийн 1-р ботид хэвлэгджээ. Дашрамд өгүүлэхэд, Монгол Улсын судлаач А.Алимаа, БНХАУ-ын эрдэмтэн Эрдэнэбилиг нар орчуулан монгол бичгээр БНХАУ-д хэвлүүлсэн байна.

Хоёр. Буриад болон Халимаг дахь монгол домгийн судалгааны товч

Буриад гаралтай эрдэмтэн Дорж Банзаров “Харын шүтлэг ба монголчуудын бөө мөргөл” (1846) бүтээлээс хойш эрдэмтэн Н.О.Шаракшинова буриад аман зохиол, түүний дотор буриадын домог зүй судалгааны бүтээлүүдэд нь багтсан бий. Тэрээр буриадын аман зохиолын төрлүүдийг судлах явцад 1978 онд “Монгол ардын тууль дахь од эрхсийн төсөөлөл” (“Сибирь болон Алс дорнодын ард түмний туульсын бүтээл” номд), 2002 онд Буриадын домгууд: өвөг дээдсийн урд эртний цуурай (Знание-сила. №8. Стр. 47-50) зэрэг өгүүлэл бичжээ.

Д.С.Дугаров “Сакральный мир бурятской Гэсэриады” сэдвээр докторын зэрэг хамгаалсан нь домог зүйн судалгаанд шууд хамааралтай юм.

Сүүлийн үед Оросын буриадын залуу эрдэмтэд домог зүйн чиглэлээр ганц сэдэвт зохиол бичиж эрдмийн зэрэг хамгаалж байна. Тухайлбал, 2000 онд М.Д.Базаров “Буриадын домог дахь од эрхсийн мотив” сэдвээр, 2005 онд Н.Н.Николева “Буриадын баатарлаг тууль дахь мангадтай ба эмэгтэй баатрын дүр” сэдвээр, 2015 онд С.Д.Малзурова “ХХ зууны 60-80 оны Сибирь болон Умардын ард түмний хүүрнэл зохиолын домог-аман зохиолын үндэс” (Малзурова С. Д.-Н, 2015, 26) сэдвээр хамгаалжээ.

ОХУ-ын Халимагийн эрдэмтэд монгол домог үлгэрийн чиглэлээр судлан бичсэн зүйл олон байна. Тухайлбал, 2009 онд М.А.Мукабенова “Халимагийн уран зохиолын найраглал-үлгэрийн домог зүйн болон аман зохиолын үндэс” сэдвээр хэлбичгийн ухааны докторын зэрэг хамгаалсан бол 2017 онд эрдэмтэн Т.А.Басангова, Т.А.Михайлева нар “Мифы, легенды и предания калмыков” (Басангова Т.Г. и др. 2017, 367) тусгай эмхэтгэл хэвлүүлжээ. Халимагийн эрдэмтэд домгийг зөвхөн халимагийн аман зохиолын хүрээнд бус харин ойрад-халимаг, монгол-ойрад-халимаг гэсэн хэлхээнд авч үзэхийг хичээж байгаа (Басаев & Чалбанова, 2008, № 11, 52-60; 2022, № 6, 150–152) нь тодорхой ажиглагддаг.

Гурав. БНХАУ-ын ӨМӨЗО-ы эрдэмтдийн судалгааны товч тойм

Өвөрмонголын эрдэмтэд домог зүйн судалгаагаа 1918 оноос эхлэн тооцох бөгөөд 1914-1918 оны бичигдсэн гэж үзэж байгаа Лувсанчойдоны “Монголын зан аалийн ойлбор” номтой холбон үзэх болжээ. Энэ ном нь хэдийгээр аман зохиолын эмхэтгэл биш боловч дотор нь цөөн үлгэр, домгийн зүйл тэмдэглэгдсэн, мөн БНХАУ байгуулагдахаас өмнө “Нялх сонин”, “Монголын ер үгийн сэтгүүл”, “Улаан бар” зэрэг сонин сэтгүүлд монгол домогт хамаатах домгийн зүйлийг найруулан нийтэлж байсан гэж тоймлож байна.

1963 онд Өвөр монголын Хэл, утга зохиол судлах газраас найруулсан “Монгол үндэстний утга зохиолын материалын эмхэтгэл” хэмээх номын I дэвтэрт “Дагинын ач”, “Бөөгийн домог” гэх мэт домог орсныг анхны эмхэтгэл гэж үзнэ.

1978 онд “Бүх улсын цөөн тоот үндэстний Утга урлагийн эрдэм шинжилгээний нийгэмлэг” байгуулагдсан бол 1980 онд Улсын үндэстний хэрэг эрхлэх комисс, Дундад улсын зохиолчдын эвлэлийн Бээжин хотод Цөөн тоот үндэстний уран зохиолын зохион бүтээх хурал, Цөөн тоот үндэстний утна зохиолын эрдэм шинжилгээний нийгэмлэгийн анхдугаар хурал (1981) зэргээс монгол үндэстний аман зохиолыг цуглуулах, эмхэтгэн хэвлүүлэх ажлыг эрчимжүүлэхээр шийдвэрлэжээ. Эдгээрийн дүнд монгол домог үлгэрийг хятад хэлнээ орчуулах ажлыг хийж 1984-1987 оны хооронд олон тооны эмхэтгэл хэвлэгдсэн байна. Тухайлбал, 1984 онд ӨМ-н Үндэстний хэвлэлийн хорооны “Монгол ардын домог үлгэрүүд”, “Сүбэй монголчуудын аман үлгэр”, “Дээд монголын аман зохиолын дээж бичиг”, “Үзэмчин аман үлгэрийн чуулган”, “Ойрад монголын ардын аман үлгэр” зэрэгт түүвэрт домгууд багтжээ.

БНХАУ-ын ӨМӨЗО-д “Монгол ардын аман үлгэрийн чуулган” (2000) 2 ботиор хэвлэгдэж, домгийг шидэт үлгэр хэмээн нэрлэж бүлэг болгожээ. “Хорчин ардын аман үлгэр” бүтээлд 260 шахам аман үлгэрийг оруулж Аман үлгэр, инээдэмт шог үлгэр, ёгт үлгэр, домог үлгэр гэж 4 хэсэгт хуваажээ. Эдгээрийг 2001-2002 оны хооронд 20 шахам үлгэрчээс тэмдэглэж авснаа тодорхой тэмдэглэжээ. Өөр нэг онцгой бүтээл бол “Хачин шидэт үлгэр, домгийн хадгаламж” эмхэтгэл юм. Түүнд Ониудын 158 үлгэр, домог багтжээ. Энэчлэн барга, Алшаа, баарин, Урад болон Сөнөд, үзэмчин зэрэг угсаатан, газар орон, хошуу нутгийн үлгэрийн эмхэтгэлүүдэд мөн л шидэт үлгэр, домог-үлгэр, домог нэрээр цөөнгүй домгууд хэвлэгдээд байна.

Судалгааны бүтээлийн хувьд, судлаач Баяр ӨМБИС-ын эрдэм шинжилгээний сэтгүүлд “Монгол, хятадын галав үүслийн шидэт үлгэрийн харьцуулал” (1988) өгүүлэл хэвлүүлсэн нь ӨМӨЗО дахь монгол домгийн судалгааны эхлэл төдийгүй болно. Түүнчлэн доктор Намжилын “Монгол домгийн харьцуулсан судлал-монгол үлгэр, домгийн харьцуулсан судлал -1” өгүүлэлд “харьцуулсан судлал цөөн хэдэн бүтээлийн нэг болно. Энэтхэгийн галав ертөнцийн үүслийн домог нь хятад домогт нөлөөлсөн гэдэг зарим хятад эрдэмтдийн үзэлтийг зөвтгөн үзсэн бөгөөд хятадын галав ертөнцийн үүслийн

домог нь бурхан шашнаар дамжин монгол домогт нөлөөлсөн гэх үзлийг дурдсан байна” (Намжил, 2011) гэжээ.

1990 онд Т.Сэнгэрэнцэнгийн “Монгол шидэт үлгэр”, 1996 онд профессор Хүрэлшаагийн “Монгол домгийн судлал” зэрэг ном бичсэн нь Монгол Улсад танил болжээ. Хүрэлшаагийн бүтээлд “Монголын нууц товчоо” дахь домгууд, Нэйж тойны намтрын доторх домгууд, хун шувууны тотем, ууль шувуу шүтлэг хийгээд угсаатны домгуудыг судалсан чамбай өгүүллүүд багтжээ. 2004 онд “Монгол домгийн соёл судлал” номоо хэвлүүлжээ.

1998 онд эрдэмтэн В.Сайнцогтын “Монгол домог үлгэрийн судлал” судалгааны ном хэвлэгдэн гарсан бол мэргэшсэн эрдэмтэд төрөн гарав. 2001 онд “Монгол домгийн харьцуулсан судлал” сэдвээр Г.Намжил хэлбичгийн ухааны докторын зэрэг хамгаалж диссертация мөн ондоо “Монгол домгийн харьцуулсан судлал-монгол үлгэр домгийн харьцуулсан судлал” нэрээр хэвлүүлэв. Оршил, удиртгал 5 бүлэгтэй тус номд Хятад болон хятадын 56 үндэстний домгийг харьцуулан үзсэн суурь шинжтэй бүтээл болно.

Өдгөө домог үлгэрийн судалгаа харьцуулсан судалгааны тийш чиглэх хандлагатай байгаа нь даяаршил, соёлын ижилслийн асуудалтай холбоотой идэвхжиж байна.

Дөрөв. Монгол Улс дахь домгийн судалгааны товч тойм

Монгол домог зүйн эх хэрэглэгдэхүүнд холбогдох бүтээлүүд харьцангуй эрт үед хэвлэгдэн дэлхий дахины сонорт хүрсэн билээ. Гэсэн хэдий ч монгол домог үлгэрийг Грек, Ромын домогтой харьцуулан үл тоомсорлох, бурхны шашнаар дамжиж орсон харийн соёлын хувилбар гэх мэт санаа ч цухалзсаар байв. Энэ талаар академич Д.Цэрэнсодном “Нэг талаар монгол домог-үлгэрийн судлалд энэ мэт бага сага амжилт гарч байгаа боловч үлгэрийн дайвар маягийн судалгаанаас хараахан ангижирч чадаагүй байгаа учраас зарим судлаачид Монголд өөрийн бие даасан домог-үлгэр байхгүй, шашны нөлөөгөөд төвөд зэрэг бусад үндэстнээс зээлдсэн зүйл бий гэдэг хөнгөмсөг дүгнэлт хийхэд хүргэжээ” (Цэрэнсодном, 2013, 13) гэжээ. Үнэндээ өнөө хэр иж бүрэн судалгаа үгүйлэгдэж байгаа юм. Дашрамд дурдахад “Хятадын домог нь дэлхийн шилдэг гэж үнэлэгддэг Европын сага (тууль) шиг биш, дэлхийн домгийн санд орохуйц, ойр дөхүү тийм боловсронгуй домог хараахан байхгүй” гэх дүгнэлтийг Америкийн эрдэмтэн Е.Вернер бичиж байжээ (Verner, 1922, 56).

Нэрт эрдэмтэн Б.Ринчений монгол домог, бөөгийн тухай өгүүлэл, номуудыг хамааруулан үзэж болно. Германы эрдэмтэн В.Хейсигийн тусламжтайгаар Б.Ринчен Весбаден хотноо “Монгол ардын аман зохиол” түүврээ “Asiatische Forschungen” (Collected by B. Rintchen, 1959-1972) цувралаар хэвлүүлсэн нь монгол аман зохиолын төдийгүй домог зүйн судалгаанд чухал бүтээл болсон юм.

Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном нарын эмхэтгэсэн “Монгол ардын аман зохиолын дээж бичиг” (УБ., 1967) нь аман зохиолын тогтолцоонд цэгцтэй

ойлголт өгөхөд чухал ач холбогдолтой төдийгүй монгол домгийн чухал боловсруулалт болсон юм.

Ш.Гаадамба, Х.Сампилдэндэв нарын “Монгол ардын аман зохиол” бүтээлд монгол домгийг “Орчлон ертөнц, хүний нийгмийн юм үзэгдэл тэргүүтнийг танин мэдэж тайлбарлах эртний хүний эрмэлзлийг тусгаж, аяндаа ухамсаргүй уран сэтгэмжээр зохиогдсон аман өгүүлэлд хүүрнэлийн зохиол” гэхчлэн тодорхойлсон нь аман зохиол судлал, шинжлэх ухаанд байр сууриа удаан хугацаанд эзэлсэн билээ. Түүнээс гадна домоглог сэтгэлгээ (домоглолын сэтгэлгээ) гэдгийг домог, домог зүйтэй зэрэгцүүлэн авч үзсэн, монгол домог үлгэрийн онцлогийг тодруулсан, домгийн ангиллыг хийсэн зэрэг алхам хийжээ (Гаадамба Ш нар, 1988).

Академич Д.Цэрэнсодном бол Монгол домог (домог-үлгэр)-ийг эмхэтгэн цуглуулах ажилд томоохон хувь нэмэр оруулсан эрдэмтэн билээ. 1989 онд “Монгол ардын домог үлгэр”-ийн анхны хэвлэл гарснаас хойш удаа дараа шинэчлэгдэн хэвлэгдсэн төдийгүй солонгос болон хятад хэлээр орчуулагдан хэвлэгджээ. 2023 онд хэвлүүлсэн хоёр дахь хэвлэлдээ монгол домгийг Ертөнцийн үүслийн тухай, Од эрхсийн тухай, Ургамал бодис, Мал, араатан амьтан жигүүртэн, хүн ба хүнчилсэн амьтан, Шашин шүтлэгийн холбогдолтой зүйл, Соёл иргэншил, Овог аймгийн үүсэл гарал гэсэн 8 зүйлд хуваан нийт 243 домог, тэдгээрийн хувилбарыг хамруулсан байна.

Профессор С.Дулам бол Монгол Улсдаа төдийгүй дэлхийд танигдсан монгол домог зүйн нэртэй төлөөлөгч юм. Тэрээр 1982 онд “Образы монгольской мифологии и литературная традиция” сэдвээр Хэлбичгийн ухааны дэд докторын зэрэг хамгаалсан бөгөөд уг бүтээлээ эх орондоо 1989 онд “Монгол домог зүйн дүр” нэрээр хэвлүүлсэн нь өдгөө олон судлаачийн ширээний ном болжээ. “Монгол домог зүйн дүр” бүтээл нь 1999 онд монгол бичгээр хөрвүүлэгдэж, 2024 орос хэлээр “Дэлхийн домгууд” цувралаар “Монгольские мифы” нэрээр хэвлэгдэн гарсан нь монгол эрдэмтний чансааг харуулсан үйл явдал юм. С.Дулам бүтээлдээ зөвхөн монгол домгийн дүрийн системийг бүрдүүлсэн төдийгүй домог зүйн судалгааны суурийг тавьж “Домог зүй гэдэг бол нийгмийн ухамсрын бусад хэлбэр урлаг, шашин, гүн ухаан, шинжлэх ухаан үүсэж хөгжихийн үндэс хөрс болдог учраас домог зүйг анхааран үзээгүйгээс эдгээр салбарын гарал үүслийн олон асуудал бүрхэг хэвээрээ үлдэнэ” (Дулам, 1989, 17), “...Монгол домог зүйг судлах нь уран зохиол, аман зохиол судлалаар зогсохгүй гүн ухаан,...нийгэм судлал, түүх, угсаатны зүй, урлагийн түүх зэрэг шинжлэх ухааны салбарын хувьд ч сонирхолтой болохыг сүүлийн үеийн шинжилгээний баримтууд нотолж байна” (Дулам, 1989, мөн тэнд) гэхчлэн олон талаас тайлбарлажээ.

Сүүлийн үед доктор С.Дуламын удирдлага дор домог зүйн чиглэлээр нэгэн сэдэвт зохиол бичжээ. Тухайлбал, Ч.Хулан 2012 онд “Монгол болон Америкийн уугалуудын домог зүйн харьцуулсан судалгаа” бүтээлээрээ докторын зэрэг хамгаалсан бөгөөд монгол домгийг Америкийн уугуул домгийн харьцуулсан судалгааг түүчээлсэн бүтээл гэж болно. Америкийн уугуул, Азийн нүүдэлчин

монголчуудын домгийн адил талыг ертөнцийн бүтэц тогтолцоо, нар сар, од эрхэс, хүний үүслийн домгийн жишээн дээр судалжээ. Монгол домог уугуул шинжээ илүү хадгалсан онцлогтой, хэсэг бусаг, тасархай энгийн өгүүлэмжтэй байдаг. Харин Америкийн уугуулуудын домогт эрч хүч, итгэл үнэмшил, өвөг дээдийн сүр хүч, захиас гэх үзэл хүчтэй шингэсэн хэмээн үзжээ.

Монгол Улсын аман зохиол судлаачдаас гадна философичид домог зүйн судалгаанд хувь нэмрээ оруулж иржээ. Философич С.Соёлмаа 2014 онд “Домгийг бүтэц, тэмдэг зүйн үүднээс шинжлэх нь (Монгол аман зохиолын жишээн дээр)” нэгэн сэдэвт бүтээлдээ Леви-Строссын бүтэц-тэмдэг зүйгээр монгол домгийн бүтцийн онцлог шинжийг тодруулах гол зорилгоо биелүүлсэн байна

Философич Ж.Отгонбаяр дэлхий дахинаа алдартай, домог судлалын суурь бүтээлүүдийг монгол хэлнээ “Софило” цувралаар орчуулж байгаа нь Монгол Улсад домог зүйн судалгаа хөгжих чухал нөхцөл болж байна. Тэрээр, 2024 онд гэхэд Ж.Ж.Фрэзерийн “Домог зүйн хүн судлал” (Ред. С.Дэмбэрэл) бүтээлийг “Софило” цувралын 10 дахь боть болгож, домог зүйч К.Малиновски, М.Моссе нарын бүтээлийг нэгтгэн “Эртний хүний сэтгэл зүй” нэрээр тус тус хэвлүүлжээ.

Дүгнэлт

Монгол үндэстний оюун санааны үнэт өв-домог бол хүмүүнлэг, байгалийн ухааны гол судлагдахуун мөртөө баялаг эх хэрэглэгдэхүүн юм. Монгол домгийг судалсан гадаадын эрдэмтэд монгол домгийг гадаадын уншигчдад хүргэх талаар ихээхэн хувь нэмэр оруулсан төдийгүй өдгөө ч санал санаачилга гарган ажилласаар байна. Тухайлбал, Унгарын монгол судлаачид домог зүйн бүтээлүүдээ цахим хэлбэрээр олны хүртээл болгож “Terebess Ázsia E-Tár” буюу “Азийн цахим номын сан”-д монгол домгуудыг орчуулан байршуулжээ. Улмаар монгол домгийг бүс нутаг болон соёлын хам орчинд монголчуудын ертөнцийг үзэх үзэл, эртий шүтлэг бишрэл, бөө мөргөл зэрэг хүрээнд авч үзэж, монгол домгийн тулгуур болон холбогдох сэдвүүдийг тодорхойлж, харьцуулсан судалгааны эхлэлийг тавьжээ.

1970 оны сүүл, 1980 оны эхэн үе бол Монгол Улс дахь домог зүйн судалгааны оргил цаг байсан нь хэвлэлийн тоймоос харагдаж байна. Монгол Улсад домгийг цуглуулах, тогтолцоотой авч үзэх, ялангуяа тэнгэр нэр (пантеон), туурвигч болон соёлын баатрууд, дүрийг системчлэх чиглэлээс олон шинжлэх ухааны үүднээс судлах судалгаа эрчимжиж байна. Мөн домог зүйн суурь бүтээлүүдийг эх хэлнээ орчуулж цувралаар хэвлүүлж байгаа хувь судлаачид талархууштай юм. Буриад, Халимаг, Өвөрмонголын судлаачид монгол домог зүйн салшгүй бүрэлдэхүүн болж бүтээл туурвилаараа чухал хувь нэмэр оруулж байгаа төдийгүй мэргэшсэн судлаачид (домог зүйч) төрөн гарсан байна.

Монгол домгийн судалгаанд дээрх мэт ололт бий болж, хэл, түүх, философи, соёл судлал зэрэг олон талаас авч үзэж, нэгэн сэдэвт бүтээлүүд хэвлэгдэж судалгааны түвшин дээшилсээр байгаа ажээ. Хэдий тийм ч монгол домгийн иж судалгаа, ялангуяа харьцуулсан домог зүйн судалгаа үгүйлэгдсээр байна.

Ном зүй

А. Монгол хэлээр:

Гаадамба Ш., Сампилдэндэв Х., (1988). *Монгол ардын аман зохиол*, ШУА. Хэл зохиолын хүрээлэн. Улаанбаатар: АБЯ-ны сурах бичиг. [Gaadam-ba, Sh., Sampildendev., Kh. *Mongol ardiin aman zokhiol*. Ulaanbaatar: Ardiin bolovsroliin yamnii surakh bichig. 1988]

Гаадамба Ш., Сампилдэндэв Х., Д.Цэрэнсодном, (1991). *Монгол ардын аман зохиол*. Монгол бичгээр. Улаанбаатар: ӨМ-ын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо: [Gaadamba, Sh., Sampildendev., Kh. Tserensodnom., D. *Mongol ardiin aman zokhiol*. Övör Mongoliin bagachuud khüükhdiin khevleliin khoroo.]

Домог үлгэр, (2015). “Монсудар” хэвлэлийн газар, Монгол хэл соёлын хүрээлэн. Улаанбаатар: Адмон. [Domog ülger. Ulaanbaatar: Admon. 2015]

Дулам, С. (2018). *Домог, бэлгэдлийн ертөнц*, Ярилцлагын ном. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Dulam, S. *Domog, Belgedliin yörtönts*. Ulaanbaatar: Soyombo printing. 2018]

Дулам, С. (2018). *Домог зүй, бөө мөргөлийн судалгаа*, МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал. Боть 1. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Dulam, S. *Domog zui, böö mörgöliin sudalgaa*. Ulaanbaatar: Soyombo printing. 2018]

Дулам, С. (2020). *Монгол домог зүйн дүр*. Монгол соёлын чуулган. Боть 1. Улаанбаатар: Битпресс. [Dulam, S. *Domog zuiin düir*. Ulaanbaatar: Bitpress. 2020]

Мандах, (2003). *Ардын аман зохиолын онол*. Леонины үндэстний хэвлэлийн хороо. [Mandakh. *Ardiin aman zokhioliin onol*. BNKHAU: Leonii undest-nii khevleliin khoroo. 2003]

Монгол утга зохиолын нэвтэрхий толь (2022). Боть 1. Ерөнхий редактор С.Байгалсайхан. Улаанбаатар: Соёмбо пресс. [Mongol utga zokhioliin nevterkhii toli. Ulaanbaatar: Soyombo printing. 2022]

Соёлмаа, С. (2019). *Домгийг бүтэц-тэмдэг зүйн үүднээс шинжлэхүй*, (Монгол аман зохиолын жишээн дээр). Улаанбаатар: Соёмбо принтинг. [Soyolmaa, S. *Domgiig бүтэц-тэмдэг зүйн үүднээс шинжлэхүй*. Ulaanbaatar: Soyombo printing. 2019]


Хулан, Ч. (2012). *Монгол болон Америкийн уугуулуудын домог зүйн харьцуулсан судалгаа*. Хэл бичгийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар: [Khulan, Ch. *Mongol bolon Amerik uuguuluudiin domog zuiin kharitsuulsan sudalgaa*. Ulaanbaatar: 2012]

Цэрэнсодном, Д. (2013). *Монгол ардын домог үлгэр*, Улаанбаатар: Номун гэрэл төв. [Tserensodnom, D. *Mongol ardiin domog ülger*. Ulaanbaatar: Nomun genel töv. 2013]

Чүлтэмсүрэн, Р. (2021). *Монгол аман зохиолын түүх*. Дэвтэр 1. Улаанбаатар: Жиком пресс. [Chültemtsüren, R. *Mongol aman zokhioliin түүх*. Ulaanbaatar: Jikom press. 2021]

Б. Гадаад хэлээр:

- Беннигсен, А.П.** (1912). *Легенды и сказки Центральной Азии*: (Различные монгольские сказки, новые легенды, повести и пр. в русском пересказе) / А.П. Беннигсен. СПб.,
- Буряад арадай түүхэ домогууд**, (1990). Буряад хэлээр. Отв. ред. С.С. Бардаханова; Сост., предисл. и коммент. В.Ш. Гунгарова. Улаан-Үдэ.,
- Дугаров, Б., С.** (2005). *Мифология бурятской Гэсэриады: восточные тэнгри* / Б.С. Дугаров. Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН.
- Dulam S., Vacek J.**, (1983). *A Mongolian Mythological Text*. Praha: Univerzita Karlova,
- Lorincz L.**, (1972). Die Mongolische Mythologie// *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae*. T. XXVII (1). Budapest, P. 103-126.
- Михайлов, В.А.**, (1996). *Религиозная мифология* / В.А. Михайлов. Улан-Удэ:
- Мифы, легенды и предания калмыков**, (2017). Подготовка текстов, пер., вступит. ст., примеч., комментарии, указатели, словарь, сверка калмыцких текстов Т.Г. Басанговой, Т.А. Михалевой; отв. ред. А.А. Бурыкин, Е.Н. Кузьмина, В.В. Куканова, Г.Ц. Пюрбеев; Калмыцкий научный центр РАН. Москва: Наука –Вост. Литература.
- Неклюдов, С.Ю.**, (1995) *Монгольская мифология: религиозные и повествовательные традиции* //Мифология и литература Востока. Москва: С. 67-77
- Уланов, А.И.**, (1974). *Древний фольклор бурят* / А.И. Уланов; АН СССР. Сиб. отд-ние. БИОН. Улан-Удэ: Бурят, кн. изд-во,
- Соёл, Мифы народов мира**, (2008). Энциклопедия. Электронное издание. Москва:
- Потанин Г.Н.**, (1881). *Очерки Северо-Западной Монголии*. Вып. 2. Пб.,
- Потанин, Г.Н.**, (1893). *Тангутско-тибетская окраина Китая и Центральная Монголия: Путешествие 1884-1886 г.* СПб., 1893. - Т. 2. - XVIII,
- Шаракшинова Н.О.**, (1980). *Мифы бурят*, Иркутск: Вост.-Сиб. кн. изд-во,



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.